



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 06 сарын 02 өдөр

Дугаар А/26

Улаанбаатар хот

Албан хаагчдын 2023 оны эхний хагас
жилийн ажлын гүйцэтгэл, үр дүн,
мэргэшлийн түвшинг үнэлэх үнэлгээний баг
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.1 дэх хэсэг, Засгийн газрын 2020 оны 218 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам"-ын 4.1 дэх заалт, Газрын дүрмийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Газрын албан хаагчдын 2023 оны хагас жилийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх үнэлгээний багийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний ахлагч:	багийн Д.Ганболд	Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга
Гишүүн:	В.Батчимэг	Бодлогын хэрэгжилтийн хэлтсийн дарга
	О.Нямбат	Гүйцэтгэлийн төлөвлөгөө, тогтоол шийдвэрийн биелэлт хариуцсан мэргэжилтэн
	Н.Алтанзаяа	Хөгжлийн бодлого төлөвлөлт, төсөл хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн
Нарийн бичгийн дарга:	Б.Энхцэцэг	Хүний нөөц, ёс зүй, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн

2. Нэгжийн дарга нар албан хаагчдын төлөвлөгөөний биелэлтийг хянаж баталгаажуулан тайланг 2023 оны 06 дугаар сарын 15-ны дотор байгууллагын үнэлгээний багт хүлээлгэн өгөхийг даалгасугай.

3. Байгууллагын үнэлгээний баг нэгжийн дарга нарын баталгаажуулсан албан хаагчдын гүйцэтгэлийн тайланг хянаж 2023 оны 06 дугаар сарын 19-ний дотор дүгнэж, хэрэгжүүлэх арга хэмжээний санал, зөвлөмжийг боловсруулан танилцуулахыг үнэлгээний баг (Д.Ганболд)-т даалгасугай.

ДАРГА *D. Batsu* Д.БАТСҮХ

1150500153